

Нягтлан бодох бүртгэл, тайлагналын тогтолцоонд нөлөөлөгч хүчин зүйлсийн үнэлгээ

Г. Гантулга¹

Хураангуй

Судалгааны зорилт нь нэгдүгээрт Монгол Улсын НББ, тайлагналын өнөөгийн тогтолцооны зарим асуудал, нөлөөлөгч гол зүйлүүдийг анхдагч болон хоёрдогч эх үүсвэрүүдээс судлан тогтоох, хоёрдугаарт орчны шинжилгээний үндсэн дээр НББ тайлагналын тогтолцоог үнэлэх, өмнөх онуудын холбогдох тайлан, судалгааны ажлуудтай танилцаж нэгтгэн дүгнэх явдал юм.

Түлхүүр үгс: нягтлан бодох бүртгэл, тайлагналын тогтолцоо, эдийн засгийн хүчин зүйлс, технологийн нөлөө, зах зээлийн хүү, инфляци

Танилцуулга

Монгол Улсад “Нягтлан бодох бүртгэл (НББ)-ийн тухай хууль” 1993 онд батлагдан мөрдөгдсөнөөс хойш НББ-ийн хөгжлийн суурь тавигдсан гэж үздэг. Энэхүү үеэс эхлэн Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС)-ыг хэрэгжүүлэх чиглэлээр төр болон олон улсын байгууллагууд Монгол улсад энэ талаар хуулийн зохицуулалтыг бий болгох, НББ-ийн боловсролыг дэмжих, аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ)-уудад Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ыг нэвтрүүлэх, мэргэжлийн шинэ байгууллага үүсгэн байгуулах, МНБ-ийн шалгалтыг бий болгох, улсын болон хувийн салбарт НББ, аудитыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг олон ажлуудыг хийж иржээ. Үүний үр дүнд Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооны үеийн хуучин НББ-ээс олон улсын шилдэг туршлагад түшиглэсэн зах зээлийн баримжаатай НББ-ийн тогтолцоонд шилжих томоохон өөрчлөлт хийгдэж байна.

Энэхүү ажлын зорилго нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудын НББ, санхүүгийн тайлагналын тогтолцооны зарим асуудлыг тодруулах, үнэлэлт дүгнэлт өгөх явдал болно.

¹ СЭЗИС-ийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн багш.
E-mail: gantulga.g@ufe.edu.mn

I. НББ, тайлагналын тогтолцоог тодорхойлогч хүчин зүйлс

Аливаа улсын НББ-ийн тогтолцоонд олон хүчин зүйлс нөлөөлдөг болохыг эрдэмтэд тогтоосон байдаг. Тэдгээрээс хамгийн их нөлөөлдөг хүчин зүйлсийг нэрлэвэл компанийн засаглал, соёл буюу ёс зүй, ААНБ-ын хэлбэр, НББ-ийн мэргэжил, эдийн засаг болон олон улсын нөлөө зэрэг болно². НББ, тайлагналын тогтолцоог дараах зурагт харуулав. Доорх загварыг ашиглан олон эрдэмтэд өөрийн улс орны НББ, тайлагналын тогтолцоонд үнэлэлт өгч цаашид хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон байдаг³.

Зураг 1. НББ, тайлагналын тогтолцоонд нөлөөлөгч хүчин зүйлс



Эх үүсвэр: Kim, "НББ, Санхүүгийн тайлагналын тогтолцоог тодорхойлогч хүчин зүйлс: БНСУ", судалгааны өгүүлээс

Засгийн газар: Засгийн газар нь санхүүгийн тайлагналын зорилго, стандарт, практикийн хөгжилд гол нөлөөлөгч хүчин зүйлсийн нэг бөгөөд ялангуяа мэргэжлийн хөгжил харьцангуй доогуур улс орнуудад маш хүчтэй нөлөө үзүүлдэг байна⁴. Санхүүгийн тайлагналын систем нь тухайн улс орны засгийн газрын бодлогоос ихээхэн хамаардаг бол татварын систем нь НББ, тайлагналын тогтолцоонд голлох үүрэг гүйцэтгэдэг. Татварын болон НББ-ийн системийн хүчтэй хамааралтай улс оронд ААНБ нь татварын өр төлбөрөө бага байлгахын тулд санхүүгийн тайлагналд уламжлалт буюу хуучин арга хандлагыг баримтлах хандлагатай байдаг.

Компанийн засаглал: Компанийн санхүүгийн тайланг бэлтгэн тайлагнах практик нь компанийн төрөл болоод бүтцийн хэлбэрээс шалтгаалан янз бүр байдаг. Тухайлбал нээлттэй хувьцаат компанийн хувьд гэр бүлийн эзэмшлийн компанитай харьцуулахад санхүүгийн тайлангийн тодруулгын хэрэгцээ өндөр байдаг.

НББ-ийн мэргэжил: Санхүүгийн тайлагналын тогтолцоонд НББ-ийн ажилтнуудын үүрэг, оролцоо нөлөөлдөг болох нь нэлээдгүй судалгаагаар батлагдсан байдаг.

² Mueller, Radcliff, Nobes, Gray, Cooke, Wallace, Meek, Adhikari

³ Youngok Kim, Determinants of Financial Reporting System

⁴ Youngok Kim, Determinants of Financial Reporting System

Эдийн засгийн хүчин зүйлс: Хөрөнгийн зах зээл, тэр дундаа үнэт цаасны зах зээл нь эдийн засгийн өсөлтөд нөлөөлөгч гол хүчин зүйл юм⁵. Хөрөнгийн зах зээл хөгжиж байгаагаас улбаалан хөрөнгө босгохоор олон оролцогч талууд, хувьцаа эзэмшигчид хамрагдаж, улмаар хувь нийлүүлэгчдийн бүтэц өргөн хүрээг хамрах болсон юм. Үүний үр дүнд нийгмийн хариуцлага болон санхүүгийн тайлангийн тодруулгын хэрэгцээ шаардлага, тайлагналын хамрах хүрээ нэмэгдэж байна (нэгдмэл тайлагнал гэх мэт). Хөрөнгийн зах зээл өндөр хөгжсөн улс орнуудад хууль эрх зүйн зохицуулалт нарийсан, санхүүгийн тайлагналын мэдээллийн хамрах хүрээ нэмэгдэж, аудитын тогтолцоо сайжрах нөлөө гардаг байна. Өндөр инфляцитай үед улс орны санхүүгийн тайлагналын тогтолцоонд инфляци чухал нөлөө үзүүлдэг бөгөөд тухайлбал хэт инфляцитай үед түүхэн өртгийн зарчим нийцэхгүй болж, үнийн индексэд тохируулах шаардлага үүсэх буюу хөрөнгийн дахин үнэлгээ хийж санхүүгийн тайлангийн мэдээллийг бодит үнэ цэнээр хэмжих хэрэгтэй болдог.

Олон улсын нөлөө: Хөгжиж буй улс орнуудын хувьд авч үзвэл хөгжингүй улс орнуудын нөлөөлөл, колоничлол ихээхэн нөлөөлдөг⁶. Хөгжингүй улс орны бизнесийн ба НББ-ийн философийн ойлголт хөгжиж буй улс орнуудад нөлөөлж улмаар ижил төсөөтэй санхүүгийн тайлагналын систем хөгждөг байна. Түүнчлэн колоничлол болон олон улсын дарамт шахалт нь олон улсад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн тайлагналын зарчим, стандартыг хэрэгжүүлэх шалтгаан болдог. Олон улсын эдийн засаг, улс төрийн хараат бус байдал, гадаадын шууд хөрөнгө оруулалт, үндэстэн дамнасан корпораци, олон улсын санхүүгийн зах зээлийн үсрэнгүй хөгжил, олон улсын байгууллагуудын үйл ажиллагаа зэрэг нь олон улсын нөлөөний хүчин зүйлс юм.

Соёл ба ёс зүй: Санхүүгийн тайлагналын системд нөлөөлөх ёс зүй ба соёлын хүчин зүйлсийн нөлөөг дэлхийн олон эрдэмтэн судалсан байдаг. Тэдний гол төлөөлөгч болох эрдэмтэн Хаапсид 1980 онд гаргасан бүтээлдээ санхүүгийн тайлагналын системтэй холбогдох үндсэн ойлголтод мэргэжлийн ёс зүй, үндэсний соёл хэмээн тодорхойлсон байдаг. Эрдэмтэд эдгээр хүчин зүйлсийг хамгийн их нөлөөтэй хүчин зүйлс хэмээн хүлээн зөвшөөрдөг ба үүний учир нь НББ-ийн мэргэжил нь тусдаа бие даасан соёлыг бүрдүүлэхээс илүү нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан урган гардаг.

II. Монголын санхүүгийн тайлагналын тогтолцоог тодорхойлогч хүчин зүйлсийн үнэлгээ

1. Засгийн газар ба эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын НББ, санхүүгийн тайлангийн чанарт улс төрийн хүчин зүйлс сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал:

- Төр бизнес холилдсон засаглалын буруу тогтолцоо (лобби, ашиг сонирхлын зөрчил гэх мэт).
- Улс төрийн тогтворгүй байдал. Тухайлбал Улсын их хурал (УИХ), Засгийн газар (ЗГ) солигдох бүр яамдын бүтэц өөрчлөгдөн, яамдын ажил хариуцсан албан тушаалтнууд солигддогдоос шалтгаалан 2-4 жил тутмын давтамжтай өөрчлөлтийн улмаас төрийн

⁵ Sedaghat et al., 1994

⁶ Radebaugh, 1975

ажил цалгардах зэрэг сөрөг нөлөө гардаг⁷.

- Яамдын ажил үүргийн биелэлт. Тухайлбал хуулийн хэрэгжүүлэгч агент болох Сангийн яам НББ-ийн арга зүйгээр хангах, хуулийн төсөл боловсруулах үүргээ биелүүлэхгүй байгаа ба тэдний зарим нэг үүргийг, тухайлбал, стандарт орчуулах зэрэг ажлыг Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт (ММНБИ) хийж гүйцэтгэж байна⁸. Санхүүгийн зохицуулах хороо бол санхүүгийн тайлангийн гол хянах үүрэг гүйцэтгэгчийн нэг боловч өөрсдийн дотоод зохион байгуулалт, хүн хүчний дутагдалтай байдал зэргээс тэдний гол үүргийн нэг болох хяналтын үүргийн хэрэгжилт муу байна.
- Бизнес дахь төрийн оролцоо. Стратегийн ач холбогдол бүхий уул уурхай, эрчим хүч, зам тээвэр зэрэг салбарууд нь төрийн өмчит компанийн хэлбэрээр оршин тогтнодог. Төрийн өмчит компаниуд алдагдалтай ажилладаг.
- Татварын бодлого. Бизнесийн салбарынхны чадамжаас давсан, тэдний оршин тогтнох чадварт сөргөөр нөлөөлөхүйц татвар хураамжийг элдэв арга механизмаар хүчилж хураан авдаг ба улмаар энэ нь албан бус эдийн засгийг бий болгож, давхар тайлангийн асуудлыг үүсгэсэн⁹.

Сүүлийн жилүүдэд хууль эрх зүйн орчинд хийгдсэн томоохон өөрчлөлт, шинэчлэлтүүдээс дурдвал:

Компанийн тухай хууль: Тус хуульд 2014 онд компанийн төрөл, компанийн засаглалтай холбоотой нэмэлт өөрчлөлтүүд орж, тухайлбал хувьцаат компанийн өөрчлөн байгуулалт, татан буугдалтын тухай шийдвэрийг зөвшөөрөх эрхийг Санхүүгийн зохицуулах хороонд олгосон байна. Мөн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хүрээнд компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулж байх талаар зааж өгсөн байна. Харин 2015 оны шинэчилсэн найруулгаар компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлт, бүртгэлийн талаар асуудлуудыг зааж өгсөн юм. Цаашид хувьцааны эзэмшлийн төвлөрөл, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийн талаар өөрчлөлт оруулахаар яригдаж байна.

НББ-ийн тухай хууль: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль нь 1993 онд анх батлагдан гарснаас хойш 2002, 2003, 2006, 2011 болон 2016 онд нийт 6 удаа удаа нэмэлт өөрчлөлт орсон. 2016 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн өөрчлөлтөөр дараах заалтууд нэмэгдсэн.

Аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтлөх ба дараах бүртгэлийн стандартуудыг баримтлана. Үүнд:

- Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт,
- Жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлагналын олон улсын стандарт,

⁷ Эдийн засгийн форум - 2015 тайлан, Төрийн ордон

⁸ Нягтлан бодох бүртгэлийн тулгамдсан асуудлаар Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнгийн тэргүүн Монгол улсын гавьяат эдийн засагч, доктор, профессор Л. Дондогтой хийсэн ярилцлагаас, <http://morningnews.mn/modules.php?name=News&file=print&sid=17730>

⁹ <http://www.mongolchamber.mn/index.php/mncci-policy-advocate/166-policy-advocate-category-1/2809-2014-04-22-100053>

- Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт.

ААНБ нь зөвхөн аудит хийлгэсэн жилийн санхүүгийн тайлан болон түүний хураангуйг аудиторын дүгнэлтийн хамт өөрийн цахим хуудсанд байршуулж ил тод болгож болно.

Шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн эхний тайлангийн жил нь улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартыг мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага нь эхний хагас жилийн санхүүгийн тайланг 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ. Харин Жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг мөрдөх үүрэгтэй ААНБ жилийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ.

ААНБ-ын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх ба ерөнхий нягтлан бодогч болон байгууллагын удирдлага санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах үүрэгтэй.

НӨАТ-ын тухай хууль: 2016 оны 1-р сарын 1-нээс НӨАТ-ын урамшууллын системийг нэвтрүүлж эхэлсэн. Эцсийн хэрэглэгчийн төлсөн НӨАТ-ын 20 хувийг буцаан олгоно. Буцааж олгох албан татвар болон урамшуулал нь улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд тухайн сар, улирал, жилд улсын төсөвт төвлөрүүлэх тухайн төрлийн татварын 30 хувиас хэтрэхгүй байна. Мөн албан татвар төлөгчид сугалааны тохирлоор урамшуулал олгож болно.

2. НББ-ийн мэргэжил

2011 оны 5 сард хийгдсэн Бүртгэл хөтлөлтийн улсын үзлэгээр улсын хэмжээнд давхардсан тоогоор 33,058 нягтлан бодогч аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлээрээ ажиллаж байна гэсэн судалгаа байна. Үүнээс 15,070 нь үндсэн орон тоонд; 17,988 нь гэрээгээр ажилладаг нягтлан бодогчид бөгөөд тэдний 30,577 нь дээд боловсролтой; 2,481 нь дунд боловсролтой; 1,787 нь мэргэшсэн нягтлан бодогч юм. Чанартай санхүүгийн тайлан бэлтгэх үндэс бол нягтлан бодогчийн мэргэжлийн боловсролын чанар, мэргэшлийн ур чадвар, ёс зүйн нэгдэл юм. НББ-ийн тухай хуулийн 17.3-т зааснаар “ААНБ нь НББ-ийн ажлыг мэргэжлийн буюу мэргэшсэн нягтлан бодогчоор гүйцэтгүүлнэ” гэж заасан боловч боловсролын систем сул, төгсөж буй мэргэжилтнүүдийн чанарын түвшин хангалтгүй байгаа нь санхүүгийн тайлангийн чанарт нөлөөлж байна. Одоогоор нягтлан бодогчдыг 3 түвшинд (Сургалтын төв - анхан шат; Их, дээд сургууль - мэргэжлийн; Мэргэжлийн төрийн бус байгууллага - мэргэшсэн) бэлтгэж байна. Эдгээр гурван институцийн алинд нь нягтлан бодогчийн мэдлэг эзэмшсэнийг харгалзалгүйгээр нягтлан бодогч гэж нэрлэдэг нь нэг талаар нягтлан бодогчдын боловсролын чанар муу гэж дүгнэхэд хүргэж байж болзошгүй юм.

Технологийн нөлөө: Сүүлийн үед мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил

НББ-ийн үйл ажиллагаанд эрчимтэй нөлөөлөх болсон. Төр болон аж ахуйн нэгжүүд тус тусдаа ажил гүйлгээ боловсруулах НББ-ийн олон төрлийн мэдээллийн системийг нэвтрүүлсэн. 2011 онд цахим гарын үсгийн тухай хуулиар санхүүгийн тайлангийн баталгаажилт электрон хэлбэрээр явагдах боломжтой болсон. Цаашид шийдвэр гаргалтад туслах болон удирдлагыг дэмжих үүрэг бүхий удирдлагын буюу стратегийн түвшний системүүдийг нэвтрүүлэх, төрийн байгууллагын нэгдсэн нэг мэдээллийн санг бий болгох, улсын хэмжээний программын архитектурыг хийх хэрэгцээ шаардлага бий болж байна. Нөгөөтэйгүүр мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын талаар нилээд ажиллах шаардлагатай байгаа юм. Сүүлийн жилүүдэд дэлхий нийтэд COSO¹⁰ дотоод хяналтын загвар дээр үндэслэгддэг COBIT¹¹ хэмээх мэдээллийн технологийн хяналтыг чухалчилдаг загвар НББ-д нилээд эрчимтэй яригдаж байна.

Аудит: Аудитын тухай хууль анх 1997 онд батлагдсан. 2006 онд тус хуульд хууль хэрэгжүүлэх төрийн бус байгууллагын нэр (ММНБИ)-ийг оруулж давуу эрх олгосон явдалд судлаачид нэлээд шүүмжлэлтэй ханддаг байна. Энэ өөрчлөлтийн нөлөөгөөр төрийн хэрэгжүүлэгч байгууллагын үүргийг ММНБИ-д хэт төвлөрүүлснээс үүдэн Сангийн Яамны НББ, аудитын стандартын хорооны стандарт арга зүй боловсруулах ажил нэлээд цалгардсан болон Санхүүгийн Зохицуулах Хорооны дотоод зохион байгуулалт сул, мэргэжилтний хүрэлцээ муу байгаатай холбоотойгоор аудитын чанарын хяналт суларсан гэж үздэг. 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар “аудитын үйл ажиллагаа”-г хараат бус зөвлөх үйлчилгээ болно гэж нэмэлт өөрчлөлт оруулсан. 2016 оны 1-р сарын 1-нээс хэрэгжиж эхлэсэн Аудитын тухай хуульд гарсан гол өөрчлөлтүүдийг дурьдвал:

- Торгуулийн хэмжээ нэмэгдсэн. Тухайлбал, энэ хуулийн 5, 6, 8 дугаар зүйл, 9.5, 12.5, 15.2, 19.5-д заасныг зөрчсөн бол аудитын хуулийн этгээдийн албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин, аудитын хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан.
- Хуулийн нэр томъёоны тодорхойлолт өөрчлөгдсөн. Тухайлбал, “Партнер” гэж аудитын гэрээт ажлыг гүйцэтгэхтэй холбогдуулан аудитын хуулийн этгээдийн өмнө аудитын дүгнэлтийн талаар хариуцлага хүлээх аудиторыг хэлнэ. “Аудитын хуулийн этгээд” гэж аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нөхөрлөл, компанийг хэлнэ. “Санхүүгийн тайланг нягтлах ажил” гэж ААНБ-ийн санхүүгийн тайлан, иргэний санхүүгийн баримтыг нягтлах үйл ажиллагааны стандартын дагуу нягтлан шалгаж, баталгаажуулах үйл ажиллагааг хэлнэ.
- Аудит баталгаажуулалтын үйл ажиллагааг чанарын хяналт, аудит, нягтлах ажил, бусад баталгаажуулалт болон холбогдох үйлчилгээний олон улсын стандартуудын дагуу, санхүүгийн тайланд хийх аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу тус тус хийж гүйцэтгэнэ.
- Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь гадаадын байгууллага бол тухайн

¹⁰ Энэ загвар нь дотоод хяналтын 5 бүрэлдэхүүн хэсгийг дотоод хяналтын 3 категоритой (Үйл ажиллагааны үр дүнтэй, үр ашигтай байдал, санхүүгийн тайлангийн найдвартай байдал, хууль эрх зүйн мөрдөлт зэрэг...) матриц байдлаар холбож нэгдсэн хяналтын системийг үнэлдэг.

¹¹ COBIT загвар нь мэдээлэл технологиор дамжуулан удирдлагыг чанартай мэдээлэлээр хангах, бизнесийн үнэ цэнэ бий болгох, үйл ажиллагаагаа сайжруулах, эрсдэлийг зохистой хэмжээнд барих, хуультай нийцүүлэх зэрэг бизнесийн оновчтой шийдвэр гаргахад дэмжих хяналтын систем.

байгууллагын нийт хувьцаа эзэмшлийн гуравны нэгээс доошгүй хувийг Монгол Улсын иргэн, мэргэшсэн нягтлан бодогч эзэмшдэг байх (өмнө нь 70% байсан).

- Аудитын ажлын баримт нь аудитын хуулийн этгээдийн өмч бөгөөд ажлын баримтыг 10 жил хадгална.
- Аудитын хуулийн этгээд нь аудиторын үйл ажиллагаанд хяналт тавих дотоод хяналтын тогтолцоо бүрдүүлж, аудитын үйл ажиллагааны чанарын хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэ талаарх хариуцлагыг аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байгаа этгээд хүлээнэ.
- Аудитын үйл ажиллагааны бүтээгдэхүүн нь дүгнэлт байна. Аудитын олон улсын стандартын дагуу санхүүгийн аудитаас бусад үйлчилгээ үзүүлсэн бол холбогдох стандартаар шаардсан тайлангууд байна. Аудитын олон улсын стандартын дагуу дотоод хяналтын ноцтой асуудлын талаар аудитын хороо, уг хороо байхгүй бол төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдэх ба энэ нь зөвлөмж хэлбэртэй байж болно.
- Санхүүгийн тайлангийн аудит, санхүүгийн тайланг нягтлах ажил болон бусад баталгаажуулах ажлыг нэг ААНБ-д дараалсан 5 жилээс илүү хугацаанд хийж гүйцэтгэхийг хязгаарласан (өмнө нь 3 жил байсан) ба солигдсоноос хойш 3 жилийн хугацаанд тухайн үйлчлүүлэгч байгууллагад аудитын үйлчилгээ үзүүлэхийг хориглосон.
- Нягтлан бодох бүртгэлийн заасан СТОУС-ыг дагаж мөрдөх болон нэгдсэн санхүүгийн тайлан гаргадаг аж ахуйн нэгж байгууллага санхүүгийн тайландаа заавал аудит хийлгэсэн байх ёстой.

3. Эдийн засгийн хүчин зүйлсийн нөлөө

Зээл, зээлийн хүү, инфляци:

Монгол улсад сүүлийн жилүүдэд инфляцийн түвшин буурч байгаа боловч зээлийн хүү өндөр хэвээр байна. Энэ нь ААНБ-уудын хөрөнгө үнэгүйдэх, бодит үнэ цэнэ материаллагаар өөрчлөгдөх эрсдлийг үүсгэж болох юм. Чанаргүй зээлийн хэмжээ өндөр хэвээр байхад зээл олголт нэмэгдсээр байна.

Хүснэгт 1: Зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь ба банкуудын жигнэсэн дундаж хүү, инфляци

| Он | Зээлийн үлдэгдэл, мян.төг | Чанаргүй зээл, мян.төг | Чанаргүй зээлийн хувь, % | Инфляцийн түвшин, % | Төгрөгийн зээлийн хүү, % |
|------|---------------------------|------------------------|--------------------------|---------------------|--------------------------|
| 2017 | 12,678,043.40 | 1,039,599.56 | 8.2 | 2.5 | 19.5 |
| 2016 | 12,422,235.90 | 1,055,890.05 | 8.5 | 1.1 | 19.7 |
| 2015 | 11,695,763.60 | 830,399.22 | 7.1 | 1.9 | 19.1 |
| 2014 | 12,502,525.70 | 625,126.29 | 5.0 | 11 | 19.5 |
| 2013 | 10,769,336.60 | 570,774.84 | 5.3 | 12.5 | 17.4 |
| 2012 | 6,990,546.30 | 293,602.94 | 4.2 | 14 | 18.2 |
| 2011 | 5,641,233.70 | 327,191.55 | 5.8 | 8.9 | 15.5 |
| 2010 | 3,264,778.00 | 375,449.47 | 11.5 | 13 | 17.9 |
| 2009 | 2,655,000.40 | 461,970.07 | 17.4 | 4.2 | 20.8 |
| 2008 | 2,635,551.60 | 189,759.72 | 7.2 | 22.1 | 20.4 |
| 2007 | 2,056,060.80 | 67,850.01 | 3.3 | 17.8 | 19.9 |

Эх үүсвэр: Статистикийн эмхэтгэл

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн тоо:

Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 22 тоот тогтоолоор улсын өмч хувьчлалын ажлыг эхлүүлэх, цаашид үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх үндсийг тавьсан юм. Харин судлаачид манай улсын үнэт цаасны зах зээлийн хөгжлийг 3 үе шаттайгаар авч үзсэн байдаг. Үүнд:

1. Өмч хувьчлалыг хэрэгжүүлсэн үе (1991-1995 он)
 - 1990 онд “Үндсэн хууль” болон Иргэний хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, иргэдийн хувийн өмчийг албан ёсоор зөвшөөрсөн.
 - 1991 онд Монголын Хөрөнгийн биржийг байгуулсан.
 - 1992 оны 2 сарын 7-нд МХБ дээр хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр улсын өмчийг хувьчлах анхны арилжаа хийгдсэн.
 - 1994 онд Үнэт цаасны анхны хууль батлагдсанаар Үнэт Цаасны Хороо байгуулагдсан.
 - 1992-1995 онуудад Засгийн газрын өмч хувьчлалын бодлогын хүрээнд улсын үйлдвэрийн нийт 476 газрыг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн, тэдгээрийн нийт 8.2 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 96.1 сая ширхэг хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан иргэдэд хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр дамжуулан эзэмшүүлсэн. Гэвч улсын томоохон үйлдвэр аж ахуйн газруудын өмч хөрөнгө үрэгдэх, үйл ажиллагаа нь зогсох зэрэг сөрөг үр дагаврууд гарсан нь өмч хувьчлалыг оновчтой үр ашигтай зохион байгуулахад учир дутагдал байсныг харуулдаг юм.
2. Үндэсний хувьцаат компаниудын хувьцааг борлуулж эхэлсэн үе (1995-2005 он)

1995 оны 8-р сараас бэлэн мөнгөний арилжаа буюу үнэт цаасны хоёрдогч зах зээлийг эхлүүлсэн. Анхдагч зах зээлд хөрөнгө оруулалтын эрхийн бичгийг хувьцаа болгосон бол хоёр дахь зах зээлд хувьцааг мөнгө болгох, хувьцаа эзэмшигчид өөр хоорондоо хувьцааг худалдан борлуулах үйл ажиллагаа хийгдсэн. Ингэснээр хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй компаниудын тоо нэмэгдэж, зах зээлийн үнэлгээ 55.7 тэрбумд хүрч, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ өссөн юм. Энэ үед хувьцаат компаниудын хувьцаа, засгийн газрын бонд зэрэг үнэт цаасны дуудлага худалдааг зохион байгуулж эхэлсэн¹².
3. Олон улсын хөрөнгийн зах зээл дээр хөрөнгө босгож эхлэх үе (2005 оноос хойш)

2005 онд “Монгол шилтгээн” хувьцаат компани анх удаа Монголын Хөрөнгийн биржид бүртгүүлж нийтдээ 44,792 ширхэг хувьцаа гаргаснаар компаниуд хувьцаагаа үнэт цаасны зах зээлд нийлүүлэх болсон нь үнэт цаасны зах зээлийн хөгжилд чухал түлхэц үзүүлсэн юм. 2006 онд Женко Тур Бюро, Зоос банк, БиДиСек зэрэг компаниуд Хөрөнгийн биржийн шалгуур үзүүлэлтийн дагуу хувьцаагаа олон нийтэд гаргаж нийт 7,654,065,460 төгрөгийн хөрөнгө оруулалтыг хуулийн этгээд болон хувь хүмүүсээс татан төвлөрүүлжээ. Хөрөнгийн зах зээлийн хөгжилтэй уялдуулан 2006 оноос Үнэт Цаасны Хороог татан буулгаж үнэт цаасны зах зээлийн хууль журмын мөрдөлтөд хяналт тавих, зах зээлийг зохицуулах эрх бүхий байгууллага болох Санхүүгийн Зохицуулах Хороог анх байгуулсан юм.

¹² http://www.naog.gov.mn/editor/files/6_%20Enkhchimeg.pdf

Үүнээс үзэхэд, 2004-2008 онуудад манай орны хөрөнгийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүд бүгд өсөж, амжилттай хөгжиж байв. Энэ нь дараах хэд хэдэн шалтгаантай байсан. Үүнд:

- Дотоодын зах зээлд хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдсэн,
- Нэгж хувьцааны үнэ өмнөх онтой харьцуулахад их хэмжээгээр өссөн,
- Дотоодын 6 компани IPO хийж, хоёр компани хувьцаа нэмж гаргасан нь зах зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн зэрэг юм.

2016 оны жилийн эцсийн байдлаар “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн бүртгэлд нийт 226 компаниуд байна.



Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн тоо сүүлийн жилүүдэд цөөрсөөр байгаа нь дараах хүчин зүйлстэй холбоотой. Үүнд:

- Гэр бүлийн бизнес эрхэлж байсан хүмүүс (ганзагын наймаачид)-ийг хүчээр компани хэмээн бүртгэлжүүлсэнээр бий болсон компанийн бүтцийн өөрчлөн зохион байгуулалт,
- Хууль эрх зүйн орчин. 2011 онд батлагдсан Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар төрийн зохицуулагч байгууллага дахь бага хэмжээний хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн механизмыг тусгасан.

2012 оноос эхлэн 75 хувиас дээш төвлөрөлтэй, өмч хөрөнгө нь үрэгдсэн компаниудыг хөрөнгийн биржийн бүртгэлээс хасах, нэмж хувьцаа гаргахыг даалгах, хаалттай компанийн хэлбэрт шилжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн авч 2014 оны байдлаар Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгэлтэй 303 хувьцаат компанийн 193 нь 75 ба түүнээс дээш хувийн төвлөрөлтэй байна. Ингэж компанийн хувьцааны хяналтын багц цөөн тооны нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн гарт төвлөрсөн нь зах зээлийн нийлүүлэлтийн талд шокын нөлөөлөл үүсгээд байна. Гэвч сүүлийн жилүүдэд хувьцаат компанийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт эрс сайжирсан төлөв ажиглагдаж эхлээд байна. Цаашид ч бүртгэлтэй компанийн тоо буурах хандлагатай байгаа бөгөөд үүний учир нь:

- Төвлөрөл өндөртэй хувьцаат компаниудын хувьд банкны богино хугацаат зээлийн эх үүсвэрийг илүүд үзэх хандлага давамгайлж байна. Одоогийн байдлаар хөрөнгийн

биржид бүртгэлтэй зөвхөн 40-50 компаниуд л арилжаанд тогтмол оролцож байна. Томоохон хувьцааны 10 хувиас доош хувь нь зах зээлд чөлөөтэй худалдаалагдаж байгаа юм.

- Хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй шинээр хувьцаа гаргасан компаниудын үйл ажиллагааны таагүй байдлаас шалтгаалан олон нийтийн дунд сөрөг мэдээлэл тархсан.
- Хөрөнгийн биржийн хөгжил удаашралтай бөгөөд оролцогчдын мэдлэг муу байна.
- Санхүүгийн зохицуулах хороо нь хөрөнгийн биржтэй хамтран хөрөнгийн биржийн дүрэм журмыг мөрдөхгүй байгаа компанийг жагсаалтаас хасах арга хэмжээ авч байна¹³.

Дэлхийн банкны Монголын санхүүгийн секторт хийсэн үнэлгээгээр бүртгэлийн журамд тусгай өөрчлөлт оруулснаар уул уурхайн компаниудыг хөрөнгийн биржид бүртгэн авах боломжтой гэж үзсэн байдаг. Тухайлбал, уул уурхайн компанийг хөрөнгийн биржид бүртгүүлэхэд түлхэц болохуйц эрмэлзлийг нь тодорхой зааж өгөх нь чухал болно. Хөрөнгө оруулагчийн үүднээс сайн засаглал, ил тод байдал, үр дүнтэй хэрэгжилтийг дэмжсэн хууль эрх зүйн болон зохицуулалтын хүрээ амин чухал юм. Зохицуулалтын тогтолцоо нь компанийн засаглал, ялангуяа санхүүгийн ил тод байдлыг зохистой шийдвэрлэх ёстой. Хөрөнгө оруулалт хийхийн тулд сайн чанартай мэдээллийг хөрөнгө оруулагчид олж авсан байх хэрэгтэй гэж Дэлхийн банкнаас зөвлөсөн байна¹⁴. Санхүүгийн ил тод байдлын суурь болсон НББ, аудитын стандартыг хэрэгжүүлэх нь чанартай мэдээллийн үндэс юм.

4. Ёс зүй, соёлын хүчин зүйлсийн нөлөө

Бодлого боловсруулагчид, түүнийг хэрэгжүүлэгч, зохицуулагч агентуудын мэргэжилтнүүд, аудиторуд, компанийн удирдлага, нягтлан бодогчдын ёс зүйн нөлөө санхүүгийн тайлангийн чанарт туйлын ач холбогдолтой билээ. Улс төрийн шилжилт, “улс төрийн хямрал”-ын улмаас НББ-ийн тогтолцооны үе шат бүхэнд ёс зүйн хэм хэмжээ алдагдаж, ашиг харах, хувийн ашиг сонирхол давамгайлах зэрэг асуудлууд бий болсон нь нэлээд шүүмжлэл дагуулсаар ирсэн. Ёс зүйг удирдах хоёр зарчим байх ба нэг нь ёс зүйн философийн үүднээс хүний өөрийн ёс зүйтэй байх хувийн зан суртахууны зарчим, нөгөө нь их хүнд хэцүү асуудлыг зан суртахууныхаа үүднээс зөвөөр харж шийдвэрлэж байх арга зам, зөвт үйлээр сайн сайхан амьдарч болно гэсэн итгэл үнэмшил зэрэг дээр үндэслэгдэнэ гэдэг. Эсвэл ёс зүйг дүрэм журмаар хөшүүрэгдэх бас нэг боломж байна. Одоогоор манай улсад ММНБИ-аас баталсан мэргэшсэн нягтлан бодогчийн ёс зүйн дүрэм, дотоод аудиторын ёс зүйн дүрэм гэх мэт дүрэм журмууд байдаг. Гадаадын

¹³ Санхүүгийн тайлан, ил тод байдлын бүртгэлийн шаардлагыг биелүүлээгүй болно. СЗХ-ноос тайлагналын шаардлагыг хангахгүй байгаа компанитай шийдвэртэй тэмцэл хийж байгаа боловч СЗХ-ны зохицуулалтын эрх одоогийн хуулиар үлэмж хумигдсан байна. Хэрэв УИХ-аас баталбал үнэт цаасны зах зээлийн шинэ хууль нь СЗХ-ны эрхийг үлэмж нэмэгдүүлэх болно.

¹⁴ Санхүүгийн секторын үнэлгээ. Cit.xx/06/2012. Retrieved from http://www-wds.worldbank.org/external/default/WDSContentServer/WDSP/IB/2012/10/11/000333038_20121011015927/Rendered/PDF/730980WPOMONGO0C0disclosed010050120.pdf, хуудас 11.

¹⁵ Энэ нь 2001 онд хөрөнгийн зах зээлд мөрдүүлэхээр FTSE группээс гаргасан ёс зүйн индекс юм. Одоогоор компанийн нийгмийн хариуцлагын шалгуур болгон уг индексийг Их Британи, АНУ, Европын зах зээл, Япон улсууд мөрдөж байна.

хөрөнгийн биржүүдэд “FTSE4Good”¹⁵ зэрэг загвараар ёс зүйн индексийг тодорхойлдог.

Соёл: “Монгол бүртгэл”-ийн түүх нь улсын түүхтэй салшгүй холбоотой хөгжсөн бөгөөд 100 орчим жил орос маягийн хөтлөлт буюу түүхэн өртгөөр бүртгэдэг консерватив хандлагатай бүртгэл хөтөлж, сүүлийн 20-иод жилд Америк маягийн хөтлөлт буюу бодит үнэ цэнийг бүртгэдэг либерал хандлагатай бүртгэл хэрэгжүүлэхээр замнаж байна.

Хүснэгт 2. Нягтлан бодох бүртгэлийн түүх (товчлон харуулав)

| Хугацаа | Монгол улсын түүх | Монгол улсын НББ-ийн түүх | Монгол улсын бизнесийн түүх | Дэлхийн НББ-ийн түүх |
|-------------|-------------------|--|---|---|
| МЭӨ IV зуун | Хүннү гүрэн | 270 стандарт код дүрс бүхий хадны бичээс ¹⁶ | Сүмбэ улсын хаан Кэбинэн 3,000 морьтой хүн дагуулан 7 түм үхэр хятадад худалдсан. | МЭӨ XV-III зуун: Мод чулуу тэмдэглэгээ “түүкен, юнейформ” |
| 13-р зуун | Хамаг Монгол | Улсын сан хоосров. Өнчдийг тэтгэх сан гэх мэт байсан. | Торгоны зам, Хархорум хот | 1494.11.10: Лука Пачоли “Давхар бичилт” |
| 17-р зуун | Манжийн дарлал | Гар тэмдэглэл бүхий бүдүүвч | Манжуудын мөнгө хүүлэл | 19-р зуун: Английн үйлдвэржилт, Америкийн НББ-ийн холбоо |
| 20-р зуун | Социализм | - Мемориал ордер хөтлөлтийн үе (1911-1960 он) - Журнал ордер хөтлөлтийн үе (1960-1990 он) | Социалист орнуудтай худалдаа, үйлдвэрлэл | НББ-ийн нэгдсэн тогтолцоо |
| 21-р зуун | Ардчилал | Америк загварын хөтлөлтийн үе (1990 оноос хойш) СТОУС | Хувьчлагдсан үйлдвэрүүд, гэр бүлийн бизнесүүдийн эхлэл | НББ-ийн нэгдсэн тогтолцоо, мэдээллийн технологи |

Монголчууд зуугаадхан жилийн өмнөөс нүүдэлчин соёл иргэншлээс суурин соёл иргэншилд шилжсэн боловч асар хурдтайгаар дэлхийтэй хөл нийлүүлэх шаардлага урган гарсан ба амьдралын хэв маягийн энэхүү өөрчлөлт нь хүмүүсийн сэтгэл, оюуны болоод ёс зүйд асар их өөрчлөлтийг авчирсан гэдэг. Манай улсын НББ-ийн хөгжлийн хувьд 1990 оны шилжилт болон түүнтэй холбоотой хууль эрх зүйн өөрчлөлтийн улмаас СТОУС-ыг хэрэглэх зайлшгүй шаардлагатай тулгарч нэвтрүүлэхдээ өөрийн улс орны онцлогт тохируулалгүй шууд авч хэрэглэсэн¹⁷ ба одоогоор 30 жилийн түүхийг бүтээгээд байна.

5. Компанийн засаглалын нөлөө

Хуучин социалист дэглэмтэй байсан улс орнуудад ноёлж байгаа засаглалын загвар Монгол улсад түгээмэл байна. Энэ нь компаниуд төрийн мэдэлд, төрийн өмчийн хувь ихтэй байгаа ба цаашид төрийн оролцоог багасгах шаардлага үүсээд байгаа юм. Мөн зах зээлийн хөгжлөөс шалтгаалан гадаад, хөндлөнгийн хяналт сул, хууль эрх зүйн орчин бүрдээгүй байна. Хувьцаа эзэмшигчдийн хяналт сул байгаагаас гүйцэтгэх удирдлага нь эзний үүрэг гүйцэтгэдэг. Хяналтгүй гүйцэтгэх удирдлагатай байгаа тул санхүүгийн болон

¹⁶ http://lkhagva_nbb.blog.gogo.mn/read/entry423103

¹⁷ Э. Жавзандулам (2010). ААНБ-ын санхүүгийн мэдээллийг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох зарим арга замууд

бусад төрлийн луйвар, гэмт хэрэг гарах нь элбэг тохиолддог¹⁸.

Компанийн засаглалыг сайжруулах хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо 2007 оны 12 сарын 26-ны өдөр доорх засаглалын кодексуудийг анх гаргасан байна.

- Монголын компанийн засаглалын кодекс,
- Банкны салбарын засаглалын зарчим,
- Төрийн өмчит аж үйлдвэрийн компанийн засаглалын кодекс.

Манай улсад компанийн засаглалын эрх зүйн орчин бүрдсээр байгаа боловч компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь хараат бус байж бие даасан шийдвэр гаргалт хангалтгүй, хувьцаа эзэмшигчдэд компанийн менежментийн үйл ажиллагаанд шууд оролцож шийдвэр гаргалтанд нөлөө үзүүлдэг, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, НББ-д тавих дотоод болон хөндлөнгийн хяналт сул зарим тохиолдолд огт байхгүй, удирдах зөвлөл болон удирдлагын гүйцэтгэлийг дүгнэх шалгуур үзүүлэлт хангалтгүй, компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээлэл олон нийтэд нээлттэй, ил тод биш зэрэг түгээмэл дутагдлууд байгаа талаар Т.Цэнд-Аюуш¹⁹ эрдэмтэн дүгнэсэн байна.

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани нь СЗХ-ны 2014 оны 162 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-т тусгагдсан ил тод, нээлттэй, эрх тэгш, хяналттай, хариуцлагатай сайн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлэн ажиллаж, нийтэд тайлагнаж байх шаардлагатай байдаг. Монголын компаниудын засаглалын хүчин зүйлийн нээлттэй байдалд үзүүлэх нөлөөллийг тооцсон загварыг ашиглан хийсэн судалгааны үр дүнд манай хамгийн сайн мэдээлэлтэй хувьцаат компаниудын нээлттэй байдлын индекс дунджаас доогуур буюу 47.9 хувь байна²⁰. Энэ нь мэдээллийн чанарт муугаар нөлөөлж, тухайн компаний үнэ цэнийг тодорхойлох боломжгүй болох ба хөрөнгө оруулагчдыг татаж нээлттэй компани гэдэг жинхэнэ утгаараа ажиллах боломжгүйд хүргэх сөрөг талтай юм. Компанийн засаглалыг сайжруулахад төр засаг, нийгмийн зүгээс олон ажлууд хийгдсээр байгаа билээ. Тухайлбал, санхүүгийн зохицуулах хороо, хөрөнгийн бирж, ТОП-20 индексийг бүрдүүлэгч хувьцаат компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нар сайн засаглалтай хувьцаат компани болохоор хичээж ажиллах “ТУНХАГ БИЧИГ”-т гурвалсан гарын үсэг зурж баталгаажуулах ажиллагааг 2014 оны сүүлээр зохион байгуулсан байна²¹. Дээрх бүгдээс дүгнэхэд хувьцаат компани нь үйл ажиллагаандаа засаглалын зарчмыг хэвшүүлэн өөрийн засаглалын түвшинг үнэлж, түүний хэрэгжилтэд зохицуулах эрх бүхий байгууллагын зүгээс хяналт тавин, заавар зөвлөгөө өгч, зохих арга хэмжээ авч хэрэгжүүлж байх нь цаашид үнэт цаас гаргагчдын хөрөнгө оруулалт татах чадварыг дээшлүүлэхээс гадна нэр хүнд, цар хүрээгээ тэлэхэд төдийгүй Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжихэд чухал хувь нэмэр болох юм.

7. Олон улсын нөлөө:

ХХ зууны төгсгөл үеийн байдлаар дэлхий нийтэд дараах 5 чиглэлийн НББ-ийн стандарт хэрэглэгдэж байв.

¹⁸ Т. Цэнд-Аюуш. Монголын компанийн засаглалыг сайжруулах арга замууд, хуудас 64

¹⁹ А. Цэрэнням (2011). Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх арга зүйн асуудал

²⁰ Т. Цэнд-Аюуш. Монголын компанийн засаглалыг сайжруулах арга замууд, хуудас 129

²¹ <http://www.mse.mn/news/show/id/1357>

Хүснэгт 3: НББ-ийн стандартын чиглэл

| I. Английн загвар (НББОУС) | II. Латин Америк/ Өмнөд Европын загвар | III. Хойд ба Төв Европын загвар | IV. АНУ-ын загвар | V. Бусад |
|---|--|--|--|----------|
| Австрали, Бахам, Фижи, Иран, Ирланд, Ямаик, Малайз, Нидерланд, Шинэ Зеланд, Никарагуа, Роудизи, Сингапур, Өмнөд Африк, Тринидад, Их Британи | Аргентин, Болив, Бразил, Колумб, Этиоп, Грек, Энэтхэг, Итали, Пакистан, Парагвай, Панам, Перу, Испани, Уругвай | Бельги, Дани, Франц, Герман, Норвеги, Швед, Швейцарь, Заир | Бермуд, Канад, Япон, Мексик, Филиппин, АНУ, Венесуэл | Чили |

Эх үүсвэр: Nair, R. D., Frank, W. J. (1998). The impact of disclosure and measurement practice of international accounting classification, *Accounting review*

Сүүлийн үед даяаршлын нөлөөгөөр дэлхийн олон улс орон өөрийн үндэсний стандартаас СТОУС-д шилжих шилжилтийг эрчимтэй хийж байна. Одоогийн байдлаар нийт 170 гаруй орон СТОУС-ийг дагаж мөрдөж байна. 2016 онд СТОУСХ-оос дэлхийн нийт 150 орны хүрээнд хийсэн судалгаанаас үзвэл эдгээр улс орнуудын 93 хувь нь буюу 139 оронд СТОУС-ыг хэрэгжүүлж байна. Судалгаанд хамрагдсан орнуудаас 84 хувь нь буюу 126 улсад бүхий л ААНБ-ууд мөрдөх шаардлага тавидаг бол 9 хувь буюу 13 улсад зарим ААНБ-уудад хэрэгжүүлэх шаардлага тавьдаг байна. Эдгээр улс орнуудаас 85 улсад ЖДААН-ын СТОУС-ыг мөрдөж байгаа бол 11 улс хэрэгжүүлж эхлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна²². НББ-ийн тухай хуульд зааснаар Монгол Улсын ААНБ дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө:

1. НББОУС (СТОУС);
2. Жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (ЖДААН-н СТОУС);
3. Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС).

Манай улсын СТОУС-ын хэрэгжилтийг хянах тогтолцооны талаар Хүснэгт 4-д харууллаа.

Хүснэгт 4: СТОУС-ын хэрэгжилтийг хянах байгууллага

| Аж ахуйн нэгж, байгууллагын төрөл | СТОУС-ын хэрэгжилтийг хянах байгууллага | | | |
|-----------------------------------|---|-----------------------------|-------------------------|-------------|
| | Сангийн яам | Санхүүгийн зохицуулах хороо | Монголын хөрөнгийн бирж | Монгол банк |
| Хувьцаат компани | | ✓ | ✓ | |
| ХХК | ✓ | | | |
| Банк | | | | ✓ |
| Даатгалын компани | | ✓ | | |
| ББСБ | | | | ✓ |

Энэ хяналтын тогтолцоонд оролцогч байгууллагууд хоорондоо уялдаа холбоо сул ажилладаг. НББ-ийн мэргэшлийн үйл ажиллагааг удирдан зохицуулах эрхийг “Аудитын тухай” хуулиар ММНБИ-д олгосон байдаг. “Аудитын тухай” хуульд зааснаар ММНБИ-д мэргэжлийн НББ-ийн мэргэшлийн шалгалтыг авах, Мэргэжлийн болон ёс зүйн дүрмийг батлах, мөрдүүлэх, мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалтанд бэлтгэх сургалтыг зохион байгуулах, мэргэжлийн тасралтгүй сургалтыг хэрэгжүүлэх, аудитын компаниудад арга

²² <http://www.ifrs.org/Use-around-the-world/Pages/Analysis-of-the-IFRS-jurisdictional-profiles.aspx>

зүйн зөвлөгөө өгч, мэдээллээр хангах эрх үүргийг олгосон байдаг. ММНБИ нь 2003 оны 11-р сараас Олон Улсын Нягтлан Бодогчдын Холбооны дэд гишүүн, 2012 онд жинхэнэ гишүүн болсон. Мөн Ази Номхон Далайн Нягтлан Бодогчдын Холбооны жинхэнэ гишүүн, Азийн Нягтлан Бодогчдын Холбооны дэд гишүүн байгууллага юм.

Сангийн Яамны дэргэдэх НББ-ийн арга зүйн хороо нь СТОУС болон түүний хэрэглээний тайлбарыг орчуулан олон нийтийн хүртээл болгох ажлыг хариуцан ажиллаж байна. Мөн жижиг дунд аж ахуйн нэгжид зориулсан СТОУС-ын танилцуулга хэвлүүлэн гаргасан байна.

Олон Улсын байгууллагуудын өгсөн үнэлгээ

Олон Улсын байгууллагуудын өгсөн үнэлгээнээс харахад санхүүгийн мэдээлэл бэлтгэх тогтолцоо сул байгаа гэсэн нь батлагдаж байна. Тухайлбал, Дэлхийн банкнаас гаргасан “өрсөлдөх чадварын индекс”-ийн зарим үзүүлэлтээс үүнийг харж болох юм. 2016 оны байдлаар засгийн газрын зохицуулалтын хямрал 82/138, засгийн газрын шийдвэр гаргалтын олон нийтэд нээлттэй байгаа байдал 72/138, компанийн ёс зүй 115/138, Санхүүгийн тайлагнал ба аудитын чадавхи 127/138, компанийн ТУЗ-ийн үр ашигтай байдал 133/138, жижиг хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг хамгаалах байдал 127/138, хөрөнгө оруулалтыг хамгаалах чадвар 8/138, бизнесийн удирдлагын боловсрол олгох үйл ажиллагааны чанар 132/138 тус тус байна. Эдгээр үзүүлэлтүүдийг өмнөх 3 жилийн өмнөх үзүүлэлттэй харьцуулбал харьцангуй буурсан (хөрөнгө оруулалтыг хамгаалах чадвараас бусад) үзүүлэлттэй байгаа нь цаашид төр засаг, мэргэжлийн байгууллагуудын зүгээс олон талт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Харьцуулсан үзүүлэлтийг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 5: Өрсөлдөх чадварын индексийн зарим үзүүлэлтүүд

| № | Үзүүлэлтүүд | 2012-2013он | | 2015-2016 он | | Өөрчлөлт |
|---|--|-------------|---------|--------------|---------|----------------|
| | | Үнэлгээ | Эрэмбэ | Үнэлгээ | Эрэмбэ | |
| 1 | ЗГ-ын зохицуулалтын хямрал | 3.0 | 102/144 | 3.3 | 82/138 | Сайжирч байгаа |
| 2 | ЗГ-ын шийдвэр гаргалтын олон нийтэд нээлттэй байдал | 3.9 | 102/144 | 4.1 | 72/138 | Сайжирч байгаа |
| 3 | Компанийн ёс зүй | 3.3 | 121/144 | 3.3 | 115/138 | Муу |
| 4 | Санхүүгийн тайлагнал ба аудитын чадавхи | 3.6 | 130/144 | 3.5 | 127/138 | Муу |
| 5 | Компанийн ТУЗ-ийн үр ашигтай байдал | 3.9 | 125/144 | 3.7 | 133/138 | Муу |
| 6 | Жижиг хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг хамгаалах байдал | 3.2 | 132/144 | 3.3 | 127/138 | Сайжирч байгаа |
| 7 | Хөрөнгө оруулалтыг хамгаалах чадвар | 6.3 | 29/144 | 7.3 | 8/138 | Сайн |
| 8 | Бизнесийн удирдлагын боловсрол олгох үйл ажиллагааны чанар | 3.0 | 132/144 | 3.1 | 132/138 | Муу |

Эх сурвалж: Дэлхийн өрсөлдөх чадварын индекс

Дээрх хүснэгтээс харахад НББ-ийн тогтолцоонд нөлөөлөгч хүчин зүйлс болох

санхүүгийн тайлагнал ба аудитын чадавхи, компанийн ёс зүй, компанийн ТУЗ-ийн үр ашигтай байдал, бизнесийн удирдлагын боловсрол олгох үйл ажиллагааны чанар зэрэг үзүүлэлт Монгол Улсын хувьд маш муу гэж үнэлэгдсэн байна.

Дүгнэлт, санал

Манай улс НББ-ийн хувьд 1990 оны шилжилт болон түүнтэй холбоотой хууль эрх зүйн өөрчлөлтийн улмаас СТОУС, АОУС-ыг хэрэглэх зайлшгүй шаардлагатай тулгарсан билээ. Тэдгээр стандартуудыг нэвтрүүлэхэд улс орныхоо онцлогт тохируулалгүй шууд авч хэрэглэсэн нь нилээн шүүмжлэлийг дагуулсаар ирсэн. Төр бизнес холилдсон, хэрэгжүүлэгч агент нь өөрийгөө хянадаг засаглалын буруу тогтолцоо, сонгуулийн давтамжтай өөрчлөгддөг яамдын бүтэц, түүнтэй холбоотой төрийн ажил цалгардалт, цалгардсан ажлыг нь төрийн бус байгууллага хуульд нэрээ монополь байдлаар баталгаажуулж аваад хийдэг, бизнесийнхний чадамжаас давсан, тэдний оршин тогтнох чадварт сөргөөр нөлөөлөхүйц, хүчлэн хураан авдаг татварын тогтолцоо, ашиг сонирхлын зөрчил зэрэг нь албан бус эдийн засгийг бий болгож, хоёр тайлангийн асуудал бий болгосон байх талтай. Эдгээрээс улбаалаад НББ-ийн тогтолцооны үе шат бүхэнд ёс зүйн хэм хэмжээний асуудлууд яригддаг.

Манай улсын санхүүгийн тайлагналын стандартын хүчин чадал дэлхийн улс орнуудын дундаж буюу 4.6 онооноос даруй 0.8 оноогоор бага, 144 орноос 127-с 130-р байранд орсон байгаа нь стандартын хүчин чадал сул байгааг харуулж байна.

Төр бизнесийн үйл ажиллагаанд хэт их оролцож байгаа нь санхүүгийн тайлагналын улс төрөөс хараат бус байх явдал хангалтгүй байгааг харуулж байгаа юм. Тухайлбал, төрийн өмчит үйлдвэрийн газрын удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагыг төрийн оролцоотойгоор байгуулдаг ба ингэхдээ ихэвчлэн улс төрийн томилгоо хийгддэг. Судалгаанаас үзвэл төрийн өмчийн оролцоотой компаниудын удирдах зөвлөлийн нийт гишүүдийн 75 хувийг Төрийн өмчийн хороо болон ЗГ-ын яам агентлагийн төлөөлөл бүрдүүлж байна. Мөн татварын бодлого тогтворгүй байсаар байна.

Хөрөнгийн зах зээлийн хөгжил сул байгаа нь санхүүгийн тайлангийн чанарт сөргөөр нөлөөлж байна. Түүнчлэн, эдийн засгийн өсөлт 2013 онд 14.4%, 2014 онд 4 хувь байсан бол 2016 онд ердөө 1 хувь болж буурсан. 2016 оны эцсийн байдлаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 300 сая америк доллар болж 2008 оныхтой харьцуулбал бараг 16 дахин буурсан байна.

Нүүдэлчин соёл иргэншлээс суурин соёл иргэншилд шилжсэн амьдралын хэв маягийн энэхүү өөрчлөлт нь хүмүүсийн сэтгэл, оюуны болоод ёс зүйд асар их өөрчлөлтийг авчирсан гэдэг. Монголын НББ-ийн түүх нь улсын түүхтэй салшгүй холбоотой хөгжсөн бөгөөд 100 орчим жил орос маягийн хөтлөлт буюу түүхэн өртгөөр бүртгэдэг консерватив хандлагатай бүртгэл хөтөлж, сүүлийн 20 жил Америк маягийн хөтлөлт буюу бодит үнэ цэнийг бүртгэдэг либерал хандлагатай бүртгэл хэрэгжүүлэхээр замнаж байна.

2013 оны Монгол улсын компанийн засаглалын үндэсний тайланд хувьцаат компанийн засаглалын үнэлгээ хангалтгүй гарсан байна. Компанийн удирдлага санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэх ач холбогдлын талаар ойлголт муу байна.

Төрийн хэрэгжүүлэгч болон хяналтын байгууллагын нэгдсэн нэг мэдээллийн санг бий болгох улсын хэмжээний программын архитектурыг хийх хэрэгцээ шаардлага бий болж байна. Нөгөөтэйгүүр мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын талаар нилээд ажиллах шаардлагатай байна. Сүүлийн жилүүдэд дэлхий нийтэд COSO дотоод хяналтын загвар дээр үндэслэгддэг COBIT хэмээх мэдээллийн технологийн хяналтыг чухалчилдаг загвар НББ-д нилээд эрчимтэй яригдаж байна.

Өнөөгийн монгол улсад компанийн засаглалын эрх зүйн орчин бүрдсээр байгаа боловч төлөөлөн удирдах зөвлөл жинхэнэ утгаараа ажиллах соёл бүрдээгүй, туршлага бага, компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээлэл олон нийтэд нээлттэй ил тод биш зэрэг түгээмэл дутагдлууд байна. Зөвлөлүүдийн ихэнх нь гүйцэтгэх удирдлагыг удирдамжаар хангах буюу үйл ажиллагаанд нь хяналт тавихын оронд компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож удирдан зохион байгуулсаар байна. ТУЗ-ийн гишүүдийг томилох үйл явц далд явагдаж байгаагийн зэрэгцээ ихэнх гишүүдийг томоохон хувь нийлүүлэгч нар томилж байна.

Оролцогч талуудын шийдвэр гаргалтад нөлөөлөх мэдээллийн үнэн зөв байх бас нэгэн баталгаа нь аудитын хороо хараат бус байх явдал юм. Монголын томоохон компаниудын аудитын хорооны хараат бус байдлыг үнэлэхэд 63% нь гүйцэтгэх удирдлагын шууд удирдлаганд үйл ажиллагаа явуулдаг, гүйцэтгэх удирдлагад тайлагнадаг, аудитын хорооны гишүүдийн цалин урамшууллыг гүйцэтгэх удирдлага тогтоодог байна. Үүнээс дүгнэхэд аудитын хорооны хараат бус байдал хангагдахгүй байна.

Дэлхийн эдийн засгийн форумаас гаргасан өрсөлдөх чадварын тайланд 2016 оны байдлаар засгийн газрын зохицуулалтын хямрал, засгийн газрын шийдвэр гаргалтын олон нийтэд нээлттэй байгаа байдал, компанийн ёс зүй, санхүүгийн тайлагнал ба аудитын чадавхи, компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үр ашигтай байдал, бага хэмжээний хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг хамгаалах байдал, бизнесийн удирдлагын боловсрол олгох үйл ажиллагааны чанар тус бүр маш доогуур үзүүлэлттэй гарсан нь цаашид төр засаг, мэргэжлийн байгууллагуудын зүгээс олон талт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Ашигласан материал

Монгол хэл дээр:

1. Дариймаа, Р. (2016). Жижиг, дунд аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийг боловсронгуй болгох нь, *Бизнесийн удирдлагын ухааны докторын судалгааны ажил*, Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль - Эрдмийн Сургууль
2. Лагнай, Т. (2016). Компанийн бондын санхүүжилтэд зэрэглэл тогтоох аргазүйн асуудал, *Бизнесийн удирдлагын ухааны докторын судалгааны ажил*, Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
3. Бямбахорлоо, С. (2015). Өрсөлдөх чадварыг өртгийн удирдлагаар дэмжих нь, *Бизнесийн удирдлагын ухааны докторын судалгааны ажил*, Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
4. Болормаа, Б. (2014). Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлагналд олон улсын стандартыг нэвтрүүлэх зарим асуудал, *Бизнесийн удирдлагын ухааны докторын судалгааны ажил*, Монгол Улсын Их Сургууль - Эдийн Засгийн Сургууль
5. Оюунцацрал, З. (2013). Монголын банкны салбарт хамтын засаглалыг хөгжүүлэх арга зам, *Бизнесийн удирдлагын ухааны докторын судалгааны ажил*, Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
6. Цэнд-Аюуш, Т. (2012). Монголын компанийн засаглалыг сайжруулах арга замууд, *Бизнесийн удирдлагын ухааны докторын судалгааны ажил*, Монгол Улсын Их Сургууль - Эдийн Засгийн Сургууль

Судалгааны тайлангууд:

7. Дэлхийн Банк, Олон Улсын Валютын сан (2008). *Нягтлан бодох бүртгэл, аудитын талаар Стандарт Дүрэм Журмын хэрэгжилтэнд өгсөн Үнэлгээний Тайлан*
8. Дэлхийн банк (2009). *Компанийн засаглалын талаар Стандарт Дүрэм Журмын хэрэгжилтэнд өгсөн Үнэлгээний Тайлан*
9. Компанийн Засаглалын Хөгжлийн Төв (2011). *Компанийн засаглалын үнэлгээний тайлан*

Гадаад хэл дээр:

10. Leonard, N. (2000). Discretionary - Accruals Models and Audit Qualifications, *Eli Bartov Stern School of Business New York University*
11. Lee, B. B., Vetter, W. (2015). Critical Evaluation of Accrual Models in Earnings Management Studies, *Journal of Accounting and Finance*, 15(1), 62-71
12. Chen, T. (2010). Analysis on Accrual-based Models in Detecting Earnings Management, *Lingnan Journal of Banking, Finance and Economics*, 2, 56-66

13. Islam, M. A., Ali, R., Ahmad, Z. (2011). Is Modified Jones Model Effective in Detecting Earnings Management? Evidence from a Developing Economy, *International Journal of Economics and Finance*, 3(2), 116-125
14. Kim, Y. (1998). Determinant of Financial Reporting System. *Dissertation of Ph.D*, University of New South Wales
15. Abdallah, A. A. J. (2013). The Impact of Using Accounting Information Systems on the Quality of Financial Statements Submitted to the Income and Sales Tax Department in Jordan, *European Scientific Journal*, special edition, 1, 41-48